

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/017/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.24 № 01/324
танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГА ДАРГА З.НЯМ-ОЧИР
ТАНАА**

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 125.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 170.4 сая төгрөгийн алдааг залруулж, орлого бүрдүүлэлт, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой 98.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг 77.4 хувьтай дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		946,385.6	1,018,202.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	594,472.4	691,740.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	127,488.0	83,156.8
УРЬДЧИЛГАА	7а, 7б	2,050.0	2,050.0
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	222,375.2	241,254.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,936,660.2	2,639,569.7
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	157,580.2	71,717.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,779,079.9	2,567,852.5
Биет хөрөнгө		1,381,901.2	2,171,053.2
Биет бус хөрөнгө	13	397,178.7	396,799.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,883,045.8	3,657,771.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,951.7	6,226.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,951.7	6,226.3
Өглөг		2,951.7	6,226.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,880,094.1	3,651,545.4
Засгийн газрын хувь оролцоо		2,880,094.1	3,651,545.4
Засгийн газрын оруулсан капитал		1,456,950.2	1,456,950.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		1,500.0	1,500.0
Хуримтлагдсан үр дүн		1,103,696.7	1,942,803.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		317,947.1	250,292.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,883,045.8	3,657,771.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,325,284.3	2,783,315.8
ТАТВАРЫН ОРЛОГО		1,113,968.7	993,925.3
Орлогын албан татвар		798,678.3	634,721.9
Хөрөнгийн албан татвар		70,662.7	133,519.7
Бусад татвар, төлбөр, хураамж		244,627.8	225,683.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	118,240.4	1,789,390.5
Тусламжийн орлого		0.0	449,102.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,093,075.2	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,931,884.3	2,009,497.0
УРСГАЛ ЗАРДАЛ		1,931,884.3	2,009,497.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,868,527.8	1,985,730.7

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		754,380.7	842,911.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		92,622.1	105,725.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		216,245.9	233,349.1
Хангамж, бараа материалын зардал		80,419.7	145,384.2
Эд хогшил, урсгал засварын зардал		63,834.3	65,649.1
Томилолт, зочны зардал		3,500.0	340.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		493,683.3	353,806.3
Бараа үйлчилгээний бусад зардал		163,841.8	238,565.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		63,356.6	23,766.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		393,400.0	773,818.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.0	2,367.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		0.0	-2,367.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		393,400.0	771,451.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,309,321.06	2,031,311.06
ТАТВАРЫН ОРЛОГО	1,113,968.74	993,925.29
Орлогын албан татвар	798,678.25	634,721.9
Хөрөнгийн албан татвар	70,662.73	133,519.71
Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,153.14	17,070.92
Газрын төлбөр	81,116.62	128,133.96
Байгалийн нөөц ашигласны төлбөр	143,358.01	80,478.81
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,277.15	1,037,385.77
Нийтлэг татварын бус орлого	102,277.15	178,589.56
Тусламжийн орлого	0.0	449,102.71
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	409,693.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,093,075.17	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,412,529.94	1,398,604.22
УРСГАЛ ЗАРДАЛ	1,412,529.94	1,398,604.22
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,346,480.59	1,374,837.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,829.53	841,665.45
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,033.49	105,809.41
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,540.33	228,616.26
Хангамж, бараа материалын зардал	42,282.02	41,423.71
Нормативт зардал	980	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	77,837.68	44,589.07
Томилолт, зочны зардал	3,500	340
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,803.94	71,855.2

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	65,673.6	40,538.84
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,049.35	23,766.29
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	896,791.12	632,706.84
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	617,203.85	535,438.46
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	617,203.85	535,438.46
Дотоод эх үүсвэрээр	617,203.85	535,438.46
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-617,203.85	-535,438.46
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,000	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-65,000	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	214,587.27	97,268.38
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	379,885.16	594,472.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	594,472.44	691,740.81

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,484,319.1	2,484,319.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,374.99	2,374.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,486,694.08	2,486,694.08
Тайлант үеийн үр дүн	393,399.96	393,399.96
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,880,094.05	2,880,094.05
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,880,094.05	2,880,094.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	67,655.1	67,655.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,947,749.15	2,947,749.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-67,655.1	-67,655.1
Тайлант үеийн үр дүн	771,451.31	771,451.31
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,651,545.36	3,651,545.36

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,350,800.8	1,921,104.9	429,695.9	81.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,446,200.8	1,414,735.4	31,465.4	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,420,586.4	1,390,969.1	29,617.3	97.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,706.8	841,665.4	14,041.4	98.4
210101	Үндсэн цалин	495,797.1	504,697.0	(8,899.9)	101.8
210102	Нэмэгдэл	301,461.4	308,624.7	(7,163.3)	102.4
210104	Урамшуулал	58,448.3	28,343.8	30,104.5	48.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,423.6	105,809.4	614.2	99.4

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210201	Тэтгэврийн даатгал	72,017.7	71,761.6	256.1	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	8,601.4	8,493.2	108.2	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,300.8	4,246.7	54.1	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,300.8	4,246.7	54.1	98.7
210205	Эрүүл мэндийн даатгал	17,202.9	17,061.3	141.6	99.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	229,844.7	228,616.3	1,228.4	99.5
210301	Гэрэл, цахилгаан	55,865.2	43,082.4	12,782.8	77.1
210302	Түлш, халаалт	168,279.5	177,885.2	(9,605.7)	105.7
210303	Цэвэр, бохир ус	5,700.0	7,648.7	(1,948.7)	134.2
2104	Хангамж, бараа материалын зардал	41,410.4	36,971.6	4,438.8	89.3
210401	Бичиг хэрэг	6,290.1	5,224.2	1,065.9	83.1
210402	Тээвэр, шатахуун	21,266.0	18,896.6	2,369.4	88.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,476.0	3,476.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,381.5	3,009.3	372.2	89.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,996.8	6,365.5	631.3	91.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,402.0	70,167.1	2,234.9	96.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,750.0	25,710.0	40.0	99.8
210604	Урсгал засвар	46,652.0	44,457.1	2,194.9	95.3
2107	Томилолт, зочны зардал	340.0	340.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	340.0	340.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,307.4	64,740.1	5,567.3	92.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,888.9	63,032.0	3,857.0	94.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209.5	-	1,209.5	-
210803	Даатгалын үйлчилгээ	200.0	200.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133.0	132.1	0.9	99.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121.0	121.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,255.0	1,255.0	-	100.0
210807	Газрын төлбөр	500.0	-	500.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,151.5	42,659.3	1,492.3	96.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,785.0	38,292.8	1,492.3	96.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,366.5	4,366.5	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,614.4	23,766.3	1,848.1	92.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,614.4	23,766.3	1,848.1	92.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,814.4	23,766.3		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800.0	-	1,800.0	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	804,600.0	506,369.5	298,230.5	62.9
223001	Бусад хөрөнгө	804,600.0	506,369.5	298,230.5	62.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	-	100,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.0	-	100,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,350,800.8	2,018,373.2	332,427.6	85.9
11	Татварын орлого	891,304.0	696,968.0	194,336.0	78.2
300001	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	563,340.0	409,835.0	153,505.0	72.8
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	436,031.9	436,031.9	-	100.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	418,124.9	409,693.5	8,431.4	98.0
120003	Торгуулийн орлого	14,000.0	35,886.5	(21,886.5)	256.3

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	23,000.0	54,698.7	(31,698.7)	237.8
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,000.0	11,146.2	(6,146.2)	222.9
120009	Бусад орлого	-	858.2	(858.2)	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,937.8
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,937.8
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,502.8
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,435.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,937.8
2104	Хангамж, бараа материалын зардал	4,452.1
210401	Бичиг хэрэг	617.0
210402	Тээвэр, шатахуун	2,585.1
210404	Ном, хэвлэл	1,250.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,456.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,456.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
3	Хоршоо хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
4	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан
5	Хатгал цахир ОНӨААТҮГ	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 282.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 277.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж 4.5 сая төгрөгийн 4 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар нийт 170.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 170.4 сая төгрөгийн орлого, зардлын хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй алдааг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 98.7 сая төгрөгийн зөрчил² илэрч 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл шууд бус орлогыг 66.9 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 1.0 сая төгрөгөөр, бууны албан татварыг 0.9 сая төгрөгөөр, газрын дуудлага худалдааг 2.6 сая төгрөгөөр нийт 71.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, нэр төрөл бүрээр биелэлтийг хангаж ажиллах

2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй холбоотой

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлд хяналт хэрэгжүүлэхэд 7 иргэн, 1 хоршооны 27.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 2 иргэнтэй холбоотой 4.4 сая төгрөгийн зээлд шүүхийн шийдвэр гарч төлөлт хийгдэж байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

3. Өр төлбөртэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь мэдээлж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алаг-Эрдэнэ сумын ТТЗ	1	170.4			1	170.4	1	170.4				
Дүн	1	170.4			1	170.4	1	170.4				
Харьяа байгууллагуудын алдаа												

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	1	277.8			1	277.8	1	277.8			
ДҮН	1	277.8			1	277.8	1	277.8			
нийт дүн	2	448.2			2	448.2	2	448.2			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алаг-Эрдэнэ ТТЗ	2	98.7					2	98.7				
Дүн	2	98.7					2	98.7				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	4	4.5			1	0.0	3	4.5				
Дүн	4	4.5			1	0.0	3	4.5				
Нийт дүн	6	103.2			1	0.0	5	103.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алаг-Эрдэнэ ТТЗ	1	0.0					1	0.0
Харьяа байгууллагуудын зөрчил								
Алаг-Эрдэнэ ЗДТГ								
Нийт дүн	1	0.0					1	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ	1	1			1			
	НИЙТ								

